



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2023 оны 12 сарын 04 өдөр

Дугаар 66

Мандалговь

Үндсэн хөрөнгө балансаас
балансад шилжүүлэх зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.1, 77.3 дахь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 09 дүгээр тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ийн 1 дүгээр зүйлийн 1.2, 1.3 дахь заалт, 5 дугаар зүйлийн 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит арванзургаадугаар хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Говь-Угтаал сумын Засаг даргын Тамгын газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 30,000,000 /гучин сая/ төгрөгийн балансын үнэтэй, 26,975,728 /хорин зургаан сая есөн зуун далан таван мянга долоон зуун хорин найм/ төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий 18-64 ДУА улсын дугаартай КАМА маркийн автомашиныг “Мандалын гэгээ” хот тохижуулах газар” Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын үндсэн хөрөнгөд балансаас балансад шилжүүлэхийг зөвшөөрсүгэй.

2. Говь-Угтаал сумын Засаг даргын Тамгын газрын дарга (Н.Өлзийтогтох), Мандалын гэгээ хот тохижуулах газар Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын дарга (Д.Очбадрах) нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай.

2.1 Шилжүүлэх хөрөнгийг байгууллагын Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналт дор хүлээлцэн, холбогдох хууль, тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.2. Энэ тогтоолын биелэлтийг 2023 оны 4 дүгээр улиралд багтаан Орон нутгийн өмчийн газарт ирүүлэх.


3. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга (Ц.Мөнхбат)-д үүрэг болгосугай.

ДАРГА



С.ОД-ЭРДЭНЭ

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2023 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн
66 дугаар тогтоолын хавсралт



Говь-Угтаал сум Засаг даргын Тамгын газар
балансаас балансад шилжүүлэх хөрөнгийн жагсаалт

№	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон огноо	Хэмжих нэгж	Тоо	Балансын үнэ	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэгдэл өртөг	Шилжүүлэн авах байгууллага
1	"КАМА" автомашин	2013.12	ш	1	30,000,000	26,975,728	3,024,272	"Мандалын гэгээ" ХТГазар
Нийт дүн				1	30,000,000 /гучин сая/ төгрөг	26,975,728 /хорин зургаан сая есөн зуун далан таван мянга долоон зуун хорин найман/ төгрөг	3,024,272.0 /гурван сая хорин дөрвөн мянга хоёр зуун далан хоёр/ төгрөг	